

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар

## Агуулга

---

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
3.Аудитын тайлан .....	14
3.1. Ерөнхий зүйл .....	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	15
3.4. Материаллаг байдал.....	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	17
3.7. Шилэн дансны мэдээлэл .....	18
3.9. Аудитын илрүүлэлт .....	18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	18
Аудитын зөвлөмж.....	19
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	19
4. Менежментийн захидал .....	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	23



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА 401  
ДҮГЭЭР ХААЛТТАЙ ХОРИХ АНГИ -  
НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ДАРГА,  
ХУРАНДАА Ш.БУЛГАН ТАНАА

2021.02.25 № 07/563  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги - Нэгдсэн эмнэлгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги - Нэгдсэн эмнэлгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын хүрээнд 27 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс хэрэгжилт нь 92 хувийн биелэлттэй байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>191,221,984.46</u></b>	<b><u>259,515,330.48</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	1,623,281.68	423,531.68
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	1,500,000.00	-
31110	Төгрөг	1,500,000.00	-
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	123,281.68	423,531.68
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	123,281.68	423,531.68
31211	Төрийн сангийн харилцах	102,981.68	423,531.68
31213	Арилжааны банк дахь харилцах	20,300.00	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	2,090,107.06	4,138,363.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	893,607.06	153,688.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	1,196,500.00	3,984,675.00
3351	Байгууллагаас авах авлага	1,196,500.00	520,675.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	3,464,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	187,508,595.72	254,953,435.80
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	80,797,481.71	146,663,483.36
35110	Тусгай зориулалттай материал	57,632,504.50	64,153,004.50
35130	Эм боох материал	23,164,977.21	82,510,478.86
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	88,746,114.01	89,817,952.44
35410	Бичиг хэргийн материал	1,815,220.00	7,744,490.00
35420	Аж ахуйн материал	57,389,199.62	52,527,556.40
35430	Сэлбэг хэрэгсэл	1,025,950.00	1,025,950.00
35440	Түлш, шатах тослох материал	1,719,200.00	4,038,700.00
35450	Барилгын засварын материал	26,404.00	26,404.00
35460	Хүнсний материал	14,595,341.85	15,965,703.50
35470	Бусад хангамжийн материал	12,174,798.54	8,489,148.54
35600	Мал амьтад	17,965,000.00	18,472,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>7,586,318,228.11</u></b>	<b><u>7,309,109,676.03</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	7,586,318,228.11	7,309,109,676.03
391	Газар	-	-
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	5,765,685,651.33	5,489,541,470.88
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,834,014,671.02	5,834,014,671.02
39202	Хуримтлагдсан элэгдэл	(776,218,778.56)	(891,116,944.60)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	243,571,000.00	243,571,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(179,335,708.80)	(193,854,925.32)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,373,135,473.46	1,371,284,760.75

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги - Нэгдсэн эмнэлгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

39206	Хуримтлагдсан элэгдэл	(837,297,374.06)	(972,850,392.23)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	255,763,642.00	260,421,744.07
39208	Хуримтлагдсан элэгдэл	(165,061,186.23)	(182,451,605.31)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	11,404,100.00	18,554,100.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	21,497,500.00	21,497,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(15,787,687.50)	(19,528,437.50)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>1,820,632,576.78</b>	<b>1,819,568,205.15</b>
39301	Програм хангамж	8,567,692.31	8,567,692.31
39302	Хуримтлагдсан элэгдэл	(7,075,115.53)	(8,139,487.16)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,819,140,000.00	1,819,140,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>7,777,540,212.57</u></b>	<b><u>7,568,625,006.51</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>3,148,606.68</u></b>	<b><u>1,394,206.68</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3,148,606.68</b>	<b>1,394,206.68</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>3,148,606.68</b>	<b>1,394,206.68</b>
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,578,250.00	450,000.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>1,570,356.68</b>	<b>944,206.68</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	100,000.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,470,356.68	944,206.68
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>7,774,391,605.89</u></b>	<b><u>7,567,230,799.83</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>7,774,391,605.89</b>	<b>7,567,230,799.83</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,469,705,487.64	2,469,705,487.64
51101	Өмч: - төрийн	2,469,705,487.64	2,469,705,487.64
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>5,304,686,118.25</b>	<b>5,097,525,312.19</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	5,304,686,118.25	5,304,686,118.25
51220	Тайлант үеийн үр дүн	-	(207,160,806.06)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>7,777,540,212.57</u></b>	<b><u>7,568,625,006.51</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,442,820,724.29</b>	<b>2,516,552,439.30</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>406,040,524.29</b>	<b>123,544,239.30</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>406,040,524.29</b>	<b>123,544,239.30</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	406,040,524.29	123,544,239.30
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	53,446,300.00	15,250,655.94
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	352,594,224.29	108,293,583.36
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,036,780,200.00</b>	<b>2,393,008,200.00</b>

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги - Нэгдсэн эмнэлгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,135,154,300.00	1,509,691,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,135,154,300.00	1,509,691,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	18,309,300.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,309,300.00	
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	883,316,600.00	883,316,600.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	883,316,600.00	883,316,600.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,487,615,159.37</b>	<b>2,690,947,845.36</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,487,615,159.37</b>	<b>2,690,947,845.36</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,479,675,125.37	2,683,525,445.36
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,385,141,900.00	1,622,581,100.00
210101	Үндсэн цалин	972,432,600.00	1,104,091,000.00
210102	Нэмэгдэл	393,826,300.00	499,607,100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,883,000.00	14,883,000.00
210104	Урамшуулал	4,000,000.00	4,000,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	33,744,977.29	42,977,420.00
210201	Тэтгэврийн даатгал	8,748,154.54	9,451,570.78
210202	Тэтгэмжийн даатгал	1,000,553.76	1,111,949.49
210203	ҮОМШӨ-ний даатгал	846,256.73	889,559.71
210204	Ажилгүйдлийн даатгал	140,077.93	158,495.37
210205	Эрүүл мэндийн даатгал	23,009,934.33	31,365,844.65
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	109,200,000.00	118,316,700.00
210301	Гэрэл, цахилгаан	53,381,617.00	58,586,792.97
210302	Түлш, халаалт	28,807,229.20	31,931,064.92
210303	Цэвэр, бохир ус	27,011,153.80	27,798,842.11
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	92,203,723.00	92,866,683.82
210401	Бичиг хэрэг	10,877,760.00	7,462,890.00
210402	Тээвэр, шатахуун	46,596,600.00	35,715,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,242,276.32	5,382,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,605,756.00	4,440,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,619,577.68	30,254,495.24
210408	Бараа материал акталсны зардал	4,261,753.00	9,611,298.58
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	419,609,264.68	458,109,909.10
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	250,015,597.45	278,297,956.19
210502	Хоол, хүнс	158,442,943.75	173,825,688.35
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,150,723.48	5,986,264.56
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	89,032,150.00	32,545,580.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	1,327,100.00



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги - Нэгдсэн эмнэлгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	764,800.00	1,044,050.00
210604	Урсгал засвар	88,267,350.00	30,174,430.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,730,000.00</b>	<b>780,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,730,000.00	780,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>16,009,136.00</b>	<b>13,902,785.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,970,670.00	8,154,530.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	3,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	676,266.00	714,055.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	224,000.00	176,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,318,200.00	1,038,200.00
210807	Газрын төлбөр	820,000.00	820,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>332,003,974.40</b>	<b>301,445,267.44</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,511,600.00	4,725,428.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,432,700.00	624,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	317,059,674.40	296,094,939.44
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>7,940,034.00</b>	<b>7,422,400.00</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>2,560,000.00</b>	<b>3,872,400.00</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	2,560,000.00	3,872,400.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>5,380,000.00</b>	<b>2,050,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,380,000.00	2,050,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>34.00</b>	<b>1,500,000.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	34.00	1,500,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(44,794,435.08)</b>	<b>(174,395,406.06)</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>726,000.00</b>	<b>32,765,400.00</b>
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	726,000.00	32,765,400.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(726,000.00)</b>	<b>(32,765,400.00)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(45,520,435.08)</b>	<b>(207,160,806.06)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,107,037,500.00</b>	<b>2,423,099,150.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>70,257,300.00</b>	<b>30,090,950.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	70,257,300.00	30,090,950.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	70,257,300.00	30,090,950.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,257,300.00	30,090,950.00

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги - Нэгдсэн эмнэлгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,036,780,200.00</b>	<b>2,393,008,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,135,154,300.00	1,509,691,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,135,154,300.00	1,509,691,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	18,309,300.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,309,300.00	-
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	883,316,600.00	883,316,600.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	883,316,600.00	883,316,600.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>2,100,113,190.25</b>	<b>2,418,051,900.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,100,113,190.25</b>	<b>2,418,051,900.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,092,553,156.25</b>	<b>2,410,629,500.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,385,141,900.00	1,622,581,100.00
210101	Үндсэн цалин	972,432,600.00	1,104,091,000.00
210102	Нэмэгдэл	393,826,300.00	499,607,100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,883,000.00	14,883,000.00
210104	Урамшуулал	4,000,000.00	4,000,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	32,865,400.00	42,977,420.00
210205	Эрүүл мэндийн даатгал	32,865,400.00	42,977,420.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	109,200,000.00	118,316,700.00
210301	Гэрэл, цахилгаан	53,381,617.00	58,586,792.97
210302	Түлш, халаалт	28,807,229.20	31,931,064.92
210303	Цэвэр, бохир ус	27,011,153.80	27,798,842.11
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	82,050,300.00	65,911,200.00
210401	Бичиг хэрэг	7,982,290.00	5,300,300.00
210402	Тээвэр, шатахуун	42,766,900.00	38,748,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,242,276.32	5,102,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,605,756.00	4,595,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21,453,077.68	12,165,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	349,883,000.00	488,349,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	218,469,134.60	336,609,000.00
210502	Хоол, хүнс	131,413,865.40	151,740,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	79,469,090.00	35,787,080.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,384,190.00	1,789,100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	764,800.00	3,237,500.00
210604	Урсгал засвар	75,320,100.00	30,760,480.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,730,000.00	780,000.00
210702	Дотоод албан томилолт	2,730,000.00	780,000.00

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги - Нэгдсэн эмнэлгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	34,531,366.25	30,797,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,492,900.25	24,492,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	3,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	676,266.00	942,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	224,000.00	224,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,318,200.00	1,318,200.00
210807	Газрын төлбөр	820,000.00	820,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	16,682,100.00	5,129,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,470,000.00	4,504,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,212,100.00	624,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>7,560,034.00</b>	<b>7,422,400.00</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	2,560,000.00	3,872,400.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	2,560,000.00	3,872,400.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	5,000,000.00	2,050,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,000.00	2,050,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	34.00	1,500,000.00
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	34.00	1,500,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>6,924,309.75</u></b>	<b><u>5,047,250.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>6,521,010.00</b>	<b>6,247,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>6,521,010.00</b>	<b>6,247,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	6,521,010.00	6,247,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,521,010.00	6,247,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(6,521,010.00)</u></b>	<b><u>(6,247,000.00)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	403,299.75	(1,199,750.00)
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	1,219,981.93	1,623,281.68
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	1,623,281.68	423,531.68

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(Төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	2,469,705,487.64	854,206,101.95	5,099,403,421.38	7,569,108,909.02
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	250,803,131.95	250,803,131.95
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>2,469,705,487.64</b>	-	<b>5,350,206,553.33</b>	7,819,912,040.97
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-854,206,101.95	-	-854,206,101.95
Тайлант үеийн үр дүн			-45,520,435.08	-45,520,435.08
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,469,705,487.64</b>	<b>-854,206,101.95</b>	<b>5,304,686,118.25</b>	6,920,185,503.94
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>2,469,705,487.64</b>	-	<b>5,304,686,118.25</b>	7,774,391,605.89
Тайлант үеийн үр дүн	-	-	-207,160,806.09	-207,160,806.09
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,469,705,487.64</b>	-	<b>5,097,525,312.16</b>	7,567,230,799.80

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(Төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,408,848,200.00	2,408,848,200.00	-	100.0
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,408,848,200.00	2,408,848,200.00	-	100.0
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,402,925,800.00	2,402,925,800.00	-	100.0
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,622,581,100.00	1,622,581,100.00	-	100.0
210101	Үндсэн цалин	1,104,091,000.00	1,104,091,000.00	-	100.0
210102	Нэмэгдэл	499,607,100.00	499,607,100.00	-	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,883,000.00	14,883,000.00	-	100.0
210104	Урамшуулал	4,000,000.00	4,000,000.00	-	100.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	42,977,420.00	42,977,420.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	42,977,420.00	42,977,420.00	-	100.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	118,316,700.00	118,316,700.00	-	100.0
210301	Гэрэл, цахилгаан	65,900,000.00	58,586,792.97	7,313,207.03	88.9

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги - Нэгдсэн эмнэлгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

210302	Түлш, халаалт	25,000,000.00	31,931,064.92	(6,931,064.92)	127.7
210303	Цэвэр, бохир ус	27,416,700.00	27,798,842.11	(382,142.11)	101.4
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>65,911,200.00</b>	<b>65,911,200.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210401	Бичиг хэрэг	5,300,300.00	5,300,300.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	38,748,100.00	38,748,100.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,102,400.00	5,102,400.00	-	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,595,000.00	4,595,000.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,165,400.00	12,165,400.00	-	100.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>488,591,500.00</b>	<b>488,591,500.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	336,851,000.00	336,851,000.00	-	100.0
210502	Хоол, хүнс	151,740,500.00	151,740,500.00	-	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>41,792,080.00</b>	<b>41,792,080.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,794,100.00	7,794,100.00	-	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,237,500.00	3,237,500.00	-	100.0
210604	Урсгал засвар	30,760,480.00	30,760,480.00	-	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>780,000.00</b>	<b>780,000.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210702	Дотоод албан томилолт	780,000.00	780,000.00	-	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>16,846,800.00</b>	<b>16,846,800.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,541,700.00	10,541,700.00	-	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	3,000,000.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	942,900.00	942,900.00	-	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	224,000.00	224,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,318,200.00	1,318,200.00	-	100.0
210807	Газрын төлбөр	820,000.00	820,000.00	-	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,129,000.00</b>	<b>5,129,000.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,504,100.00	4,504,100.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	624,900.00	624,900.00	-	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,922,400.00</b>	<b>5,922,400.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>3,872,400.00</b>	<b>3,872,400.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	3,872,400.00	3,872,400.00	-	100.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,050,000.00</b>	<b>2,050,000.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,050,000.00	2,050,000.00	-	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,408,848,300.00</b>	<b>2,408,848,300.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги - Нэгдсэн эмнэлгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,509,691,600.00	1,509,691,600.00	-	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,509,691,600.00	1,509,691,600.00	-	100.0
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	883,316,600.00	883,316,600.00	-	100.0
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	883,316,600.00	883,316,600.00	-	100.0
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	15,840,100.00	15,840,100.00	-	100.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,840,100.00	15,840,100.00	-	100.0
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	1,500,000	(1,500,000)		100.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	121	121	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	120	120	-	100.0

### **3.Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги-нэгдсэн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүн дүгнэлтийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги-нэгдсэн эмнэлгийн дарга, хурандаа Ш.Булган танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2020 оны 12 дугаар сарын 23-наас 2021 оны 02 дугаар сарын 25–ны хооронд “Голден пэйж Аудит” ХХК-ийн захирал С.Оюунгэрэл, ахлах аудитор Я.Оюун, шинжээч Б.Дашням, А.Энхтүвшин, Б.Ариун-эрдэнэ нар хариуцаж хэрэгжүүлэв.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги–нэгдсэн эмнэлгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Голден пэйж Аудит” ХХК-д 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01/57 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги–нэгдсэн эмнэлгийн эрхэм зорилго нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих ангиудад ял эдэлж байгаа хоригдлуудад эмнэлгийн тусламж, үйлчилгээ тасралтгүй чанартай үзүүлэх, өвчнийг эрт үед нь оношлох, өвчнөөс урьдчилан сэргийлэх, хоригдол бүрт хүрч үйлчлэхэд оршино.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги–нэгдсэн эмнэлгийн дүрэм шинэчлэгдэн батлагдаж, тус эмнэлгийг аймгийн нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандартаар зохион байгуулагдахаар статусыг тогтоож 120 ортой, дотор, мэдрэл, мэс засал, онош зүй гэсэн 4 тасагтай, 2 дугаар шатлалаар хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээг үзүүлдэг ба уламжлалт, физик эмчилгээ, дасгал хөдөлгөөнийг сэргээн засах эмчилгээ , зүрх судас, нүд, чих хамар хоолой, шүдний кабинет, хүлээн авах эрчимт эмчилгээ, яаралтай тусламж, эмийн сан ариутгалын хэсгүүдтэй үйл ажиллагаа явуулж байна. Мөн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих ангийн эмнэлгийн салбарын мэргэжлийн удирдлагаар ханган ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйл “нягтлан бодогчийн ерөнхий үүрэг”; 11 дүгээр зүйл “нягтлан бодох бүртгэлийн баримт болон санхүүгийн тайланг хадгалах”;
- Нийгмийн даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйл “хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага”;
- ХХОАТ-ын тухай хуулийн 23 дугаар зүйлд “албан татварын хөнгөлөлт” заалтуудад тус тус өөрчлөлт орсон байна.

### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги-нэгдсэн эмнэлэг нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна. Байгууллагын дотоод аудит хяналт шалгалт хийхдээ байгууллагын үйл ажиллагаанд хийж, санхүүгийн үйл ажиллагаанд хийгээгүй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги-нэгдсэн эмнэлгийн бэлтгэсэн эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянаж дотоод хяналтыг үр нөлөөгүй гэж үзлээ.

### **3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 2,723,713.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 54,474.3 мянган төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### **3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги-нэгдсэн эмнэлгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 208,915.1 мянган төгрөгөөр буюу 2.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.



Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,623.3	423.5	-1,199.8
Авлага	2,090.1	4,138.3	2,048.2
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	187,508.6	254,953.4	67,444.8
Үндсэн хөрөнгө	7,586,318.3	7,309,109.7	-277,208.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>7,777,540.2</b>	<b>7,568,625.1</b>	<b>-208,915.1</b>
Өр төлбөр	3,148.6	1,394.2	-1,754.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	7,774,391.6	7,567,230.8	-207,160.8
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>7,777,540.2</b>	<b>7,568,625.1</b>	<b>-208,915.1</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 423.5 мянган төгрөг болж 1,199.8 мянган төгрөгөөр буурсан нь кассанд дахь бэлэн мөнгө 1,500.0 мянган төгрөгөөр буурч, ялтаны нэрийн данс 102.9 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 4,138.3 мянган төгрөг болж 2,048.2 мянган төгрөгөөр өссөн нь байгууллагаас авах авлага 520.7 мянган төгрөгөөр нэмэгдэж, ажиллагсадтай холбоотой авлага 897.6 мянган төгрөгөөс 153.7 болж хасагдаж, хувь хүмүүсээс авах авлагын дүн 3,464.0 мянган төгрөг болж өссөнөөс шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2019-2020 онуудад үүссэн, 520.7 мянган төгрөгийг байгууллагаас, 3,464.0 мянган төгрөгийг хувь хүнээс авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 254,953.4 мянган төгрөг болж 67,444.8 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалттай материал 6,520.5, эм боох материал 59,345.5, бичиг хэргийн материал 5,929.3, түлш 2,319.5, хүнсний материал 1,370.3 мянган төгрөгөөр тус тус өссөнөөс шалтгаалжээ.

Энэ нь Ковид цар тахлын улмаас хоригдлын тоо багассантай холбоотой бараа материалын зардал буурсан байна.

Тайлант онд Хорих ял эдлүүлэх албаны газраас үнэ төлбөргүй 85,701.1 мянган төгрөгийн бараа материал шилжүүлэн авсан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Хөрөнгө шилжүүлэх тухай” А/208 дугаар тушаалын дагуу 11,785.9 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэн авсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7,309,109.7 мянган төгрөг болж 277,208.6 мянган төгрөгөөр буурсан нь 8,928.9 мянган төгрөгийн бараа материал акталж, 269,094.9 мянган төгрөгийн элэгдлийн зардал байгуулснаас шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 6,247.0 мянган

төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн мянган төгрөгийн 12,639.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгөөс ТӨБЗГ-ын 2020 оны 313 дугаар тогтоолын дагуу 8,928.9 мянган төгрөгийг акталсан байна.

Биет бус хөрөнгө 1,064.4 мянган төгрөгөөр буурсан. Энэ нь хорогдуулалтын зардал 1,064.4 мянган төгрөг өссөнөөс шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,394.2 мянган төгрөг болж 1,754.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант жилд эм, урсгал засвар, бусад зардал зэрэг байгуулагад төлөх өглөг төлж барагдуулснаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэлд онуудын 2019-2020 хоолны өглөг 450.0 мянган төгрөг, ялтны нэрийн дансны өглөг 944,206.7 төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,567,230.8 мянган төгрөг болж 207,160.8 мянган төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан үр дүн данс буурснаас шалтгаалжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги–нэгдсэн эмнэлгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 73,731.6 мянган төгрөгөөр буюу 3 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал үйл ажиллагааны санхүүжилтын орлого байна. Энэ нь ажилчдын цалин хөлс болон нэмэгдэл суутгалын зардал өссөнөөс шалтгаалж урсгал үйл ажиллагааны санхүүжилтийг өсгөж батлуулснаас шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 364,412.7 мянган төгрөгөөр буюу 15.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлсний зардал, даатгалын зардал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамжийн материалын зардал, норматив зардал гэх зардлууд байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,408,848.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,408,848.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,500.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 2,410,348.2 мянган төгрөгөөр баталсан байна.

### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн 27 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,408,848.3 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 1,509,691.6 мянган төгрөгийг, эрүүл мэндийн даатгалын сангаас 883,316.6 мянган төгрөгийг, 15,840.1 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,509,691.6 мянган төгрөгийн, эрүүл мэндийн даатгалын сангаас 883,316.6 мянган төгрөгийн санхүүжилт тус тус олгогдож, 15,840.1 мянган төгрөгийн туслах үйл ажиллагааны орлого нийт 2,408,848.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,408,848.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,408,848.3 мянган төгрөг буюу 100 хувьтай байна.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 140 мэдээллийг хугацаанд нь, 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

### **3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,921.0 мянган төгрөгийн зөрчилд өгсөн 3 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувь хэрэгжүүлэн ажилласан.

### **3.9. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 25,368.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1 албан шаардлага хүргүүлж, 25,368.1 мянган төгрөгийн 5 зөвлөмж зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

#### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Залруулагдаагүй алдаа, зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд хугацаа хоцорсон 9 мэдээлэл оруулсан байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-т “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 25,368.1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

#### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас олгогдсон Зайсангийн аман дахь 5.3 га газрыг аялагч түр буудаллах, отоглох, орон байрыг ашиглах зориулалтаар 0171217 гэрчилгээний дугаартай газарт бүртгэгдсэн 1,716,140.0 мянган төгрөгийн өртөгтэй газар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар орон сууцны барилга барьж зориулалт бусаар ашиглалт тодорхойгүй, солбилцлын цэг зөрүүтэй байна.

Тус байгууллагын эмийн худалдан авалт үнэ өртөгийн тооцооны талаар дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

#### **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### **1. Худалдан авалтын талаар**

###### **1.1. Илрүүлэлт:**

Үнэлгээний хороо нь худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа тендерт оролцогчдын материалыг дутуу бүрдүүлсэн, нээлтийн тэмдэглэл, үнэлгээний дүгнэлт, гэрээ байгуулах эрх олгох тухай зөвлөмжийг бүрдүүлээгүй, баримт материал бүрэн архивлаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49.1-т “захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална”, 49.2.4-т “захиалагч, тендерт оролцогчтой харилцсан албан бичиг”; 49.2.5-т “тендерт оролцогчдын ирүүлсэн тендер”; 49.2.6-т “тендерийн нээлтийн тэмдэглэл, үнэлгээний дүгнэлт, гэрээ байгуулах эрх олгох тухай зөвлөмж”; гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

###### **1.2. Эрсдэл:**

Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байх.

###### **2.3 Өгсөн зөвлөмж:**

Худалдан авах ажиллагааны хууль журмын дагуу баримт материалыг бүрэн бүрдүүлж, архивын нэгж үүсгэх.

###### **2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар**

Хэрэгжүүлэн ажиллана.

##### **2. Анхан шатны баримтаар**

###### **2.1. Илрүүлэлт:**

Татварын цахим баримтаар худалдан авалтанд Шатахууны худалдан авалт хийхдээ 2,849.6 төгрөгийн баримт бүрдүүлээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-т "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", гэсэн тус тус заалтуудтай нийцээгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### **2.2. Эрсдэл:**

Санхүүгийн анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй байх.

###### **2.3. Өгсөн зөвлөмж:**

Шатахууны анхан шатны баримтын бүрдлийг хангах, цахим баримтыг бүрдүүлэх

###### **2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Хэрэгжүүлэн ажиллана.

### **3. Өглөгийн данстай холбоотой асуудал**

#### **3.1. Илрүүлэлт:**

Татварын тайлангаар агаарын бохирдлын төлбөр 502.7 мянган төгрөг, АТӨЯХАТ 7,398.7 мянган төгрөг, зам ашигласны төлбөр 4,124.1 мянган төгрөг нийт 12,025.3 мянган төгрөгийн өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцээгүй, иж бүрэн, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй байна.

#### **3.2. Эрсдэл:**

Тооцоо нийлээгүйгээс авлага, өглөгийн асуудал үүсэх

#### **3.3. Өгсөн зөвлөмж:**

Байгууллагын эзэмшилд байхгүй тээврийн хэрэгслийг хасуулах тухай хүсэлт Татварын байгууллагад гаргаж, өрийн асуудлыг шийдвэрлүүлэх

#### **3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### **4. Тайлагналтай холбоотой асуудал**

#### **4.1. Илрүүлэлт:**

Хан-Уул дүүргийн 11-р хорооны нутаг дэвсгэрт орших 1 га газрын 15 жилийн хугацаатай, 000439257 тоот газар эзэмших эрхийн гэрчилгээтэй конторын зориулалтаар эзэмшүүлэхээр олгосон, эмнэлгийн зориулалтаар үйл ажиллагаа явуулж байгаа нь газрын зориулалт, хаяг байршлын өөрчлөлтийг хийлгүүлээгүй байна. Энэ нь Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2-т "үл хөдлөх эд хөрөнгийн байршлын хаяг өөрчлөгдөх", 13.1.3-т "үл хөдлөх эд хөрөнгийн зориулалт өөрчлөгдөх" гэж заасныг хэрэгжүүлэн тус тус ажиллаагүй байна.

#### **4.2. Эрсдэл:**

Тайлан хэрэглэгчдийг буруу мэдээллээр хангах

#### **4.3. Өгсөн зөвлөмж:**

Байгууллагын газрын холбогдох бичиг баримтын өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх

#### **4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Хэрэгжүүлэн ажиллана.

## **5. Тайлагналтай холбоотой асуудал**

### **5.1. Илрүүлэлт:**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын албан тоот бичгээр хандивын аян өрнүүлэн ажилчдын цалингаас 5,120.0 мянган төгрөг, сэтгүүл, ногооны үнэ, хөдөлмөр хамгаалал нэрээр 5,373.2 мянган төгрөг, нийт 10,493.2 мянган төгрөг Төрийн өмчит Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, үйл ажиллагааны ашиг гэсэн нэрээр дээд газартаа орлого төвлөрүүлсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.2 -т “Төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх”, 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" гэж заасныг хэрэгжүүлэн тус тус ажиллаагүй байна.

### **5.2. Эрсдэл:**

Тайлан хэрэглэгчдийг буруу мэдээллээр хангах

### **5.3. Өгсөн зөвлөмж:**

Хандивын аян өрнүүлэхгүй байх, албан тоотоор шаардахгүй байх, Төрийн чиг үүрэгт хамааралгүй ажил гүйлгээ хийхгүй байх

### **5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Хэрэгжүүлэн ажиллана.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:

2020

Шалгагдсан  
байгууллагын нэр:

Аудитын  
нэр:

*Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги – Нэгдсэн эмнэлгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд*

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 401 дүгээр хаалттай хорих анги - Нэгдсэн эмнэлэг**

Аудитын код:

САГ-2021/165/СТА-ТШЗ

Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Хан-Уул дүүргийн 11-р хорооны нутаг дэвсгэрт орших 1 га газрын 15 жилийн хугацаатай, 000439257 тоот газар эзэмших эрхийн гэрчилгээтэй конторын зориулалтаар эзэмшүүлэхээр олгосон, эмнэлгийн зориулалтаар үйл ажиллагаа явуулж байгаа нь газрын зориулалт, хаяг байршлын өөрчлөлтийг хийлгүүлээгүй байна.		Зөвлөмж	Дарга, хурандаа Ахлах нягтлан бодогч, хошууч	Ш.Булган Б.Баярмаа
2	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын албан тоот бичгээр хандивын аян өрнүүлэн ажилчдын цалингаас 5,120.0 мянган төгрөг, сэтгүүл, ногооны үнэ, хөдөлмөр хамгаалал нэрээр 5,373.2 мянган төгрөг, нийт 10,493.2 мянган төгрөг Төрийн өмчит Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, үйл ажиллагааны ашиг гэсэн нэрээр дээд газартаа орлого төвлөрүүлсэн.	10,493.2	Зөвлөмж	Дарга, хурандаа Ахлах нягтлан бодогч, хошууч	Ш.Булган Б.Баярмаа
3	Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна	-	Албан шаардлага	Дарга, хурандаа Ахлах нягтлан бодогч, хошууч	Ш.Булган Б.Баярмаа
4	Татварын цахим баримтаар худалдан авалтанд Шатахууны худалдан авалт хийхдээ 2,849.6 төгрөгийн баримт бүрдүүлээгүй байна.	2,849.6	Зөвлөмж	Дарга, хурандаа Ахлах нягтлан бодогч, хошууч	Ш.Булган Б.Баярмаа



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги - Нэгдсэн эмнэлгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

5	Татварын тайлангаар агаарын бохирдлын төлбөр 502.7 мянган төгрөг АТӨЯХАТ 7,398.7 мянган төгрөг зам ашигласны төлбөр 4,124.1 мянган төгрөгний өглөгийг тус тус санхүүгийн тайлатайлагнаагүй байна.	12,025.3	Зөвлөмж	Дарга, хурандаа Ахлах нягтлан бодогч, хошууч	Ш.Булган Б.Баярмаа
6	Үнэлгээний хороо худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа тендерт оролцогчдын материалыг дутуу бүрдүүлсэн, нээлтийн тэмдэглэл, үнэлгээний дүгнэлт гэрээ байгуулах эрх олгох тухай зөвлөмжийг дутуу бүрдүүлэн худалдан авалт хийсэн.	0	Зөвлөмж	Дарга, хурандаа Ахлах нягтлан бодогч, хошууч	Ш.Булган Б.Баярмаа
<b>ДҮН</b>		<b>25,368.1</b>			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 183/А0160062

Улаанбаатар хот

СЭГ- 002/165/СТА-ТЧЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу хийсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги – Нэгдсэн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын шилэн дансны цахим хуудсанд байршуулах нийт 149 мэдээллээс 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-д “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”; гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд ил тод, бүрэн байршуулж биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги – Нэгдсэн эмнэлгийн дарга, хурандаа Ш.Булган, ахлах нягтлан бодогч, хошууч Б.Баярмаа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АХЛАХ АУДИТОР  
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ  
“ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ” ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Б.ЭНХЖИН

С.ОЮУНГЭРЭЛ





## ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing.